



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын үйл
ажиллагааны стратеги, зохион
байгуулалтын хөтөлбөр, бүтцийг
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын “Агентлаг байгуулах тухай” 2022 оны 499 дүгээр тогтоол, Засгийн газрын “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2022 оны 487 дугаар тогтоол, Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 276 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөрийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргад даалгасугай.

САЙД  Н.УЧРАЛ



1523010517

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (цаашид "Газар" гэх)-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэх, зөвлөгөө, мэдээллээр хангах, үйл ажиллагааг боловсронгуй болгох, хяналт тавих чиг үүргийг зохицуулах үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Энэ хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18^д дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоол, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 69 дүгээр тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;
- Цахим гарын үсгийн тухай хууль;
- Шуудангийн тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Холбогдох бусад хууль, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, стандарт.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, төрийн захиргааны шинэчлэл, бусад улс орны ижил төстэй байгууллага болон өмнөх арга хэмжээний туршлагад үндэслэсэн арга зүйг ашиглалаа. Мөн салбарын тулгамдаж байгаа асуудал, стратеги, үйл ажиллагааны гол зорилт, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход хэрэглэдэг арга зүйг ашиглав.